

2019.05.20

Батлав: Дорнод аймгийн Баян-Уул сумын
Засаг дарга...
Х.Баттулга



**БАЯН-УУЛ СУМЫН ӨВӨР-ЭРЭЭН БАГИЙН НУТАГТ БҮЙ
“ЦАГААН ДЭВИЙН БУЛАГ”-ИЙН ХЭСГИЙГ ХАМГААЛАХ, ТОХИЖУУЛАХ
АЖЛЫН ЗУРАГ ТӨСӨВ БОЛОВСРУУЛАХ ДААЛГАВАР**

1. Зураг төсөв зохиох үндэслэл: Баян-Уул сум ЗДТГазар. Аймгийн Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх сангийн зардлаар.

2. Захиалагч: Баян-Уул сум. ЗДТГазар

3. Барилга байгууламжийн нэр, байршил: Баян-Уул сум 6-р багт. “ЦАГААН ДЭВИЙН БУЛАГ, РАШААН”-ы хэсгийг хамгаалах, тохижуулах

4. Архитектур төлөвлөлтийн шаардлага, хүчин чадал: Орон нутгийн чанартай рашааныг ундуруулдаг уг булаг /элэг, цөс, хоол боловсруулах эрхтэнд сайн гэгддэг/ нь ОХУ руу гардаг босоо тэнхлэгт засмал замын дагуу sumaas 31км-т байрладаг, аялагч, иргэдийн байнга очдог газар бөгөөд өөр хот, аймаг sumaas иргэд байнга очин уг рашааныг залдаг болоод байгаа нь хамгаалах үндэслэл нь болж ундаргыг нь тасалдуулахгүй, ойр орчмын экологийн тэнцвэр алдагдахаас сэргийлж, аялал жуулчлал хөгжүүлэхэд дэмжлэг үзүүлнэ.

1. Хамгаалах ажлын үндсэн даалгавар:

1. Рашаан авдаг хэсгийн хашаажуулсан дотор байгалийн чулуугаар усан сан үүсгэх:

-Уг усан сан нь рашааныг хадгалах зориулалттай биш бөгөөд рашаан дундуур нь урсан гарах зориулалттай байна. Усан санг хийхдээ байгалийн хавтгай чулуугаар ямар нэгэн барьцалдуулагч материал оруулалгүйгээр үелэн өрж рашааныг утган авах зориулалттайгаар засна.
/1.5x1.5 метр/

-Рашаан авах зориулалттайгаар хашсан хашааны будгийг сэргээх бөгөөд квадрат төмрөн шон болон хайс болгоны оройд борооны уснаас хамгаалсан гоёлын хамгаалалт хийж өгөх.

2. Автомашины зогсоолоос булаг хүртэл 150 метр замыг 1 метрийн өргөнөөр байгалийн ердийн хавтгай чулууг газарт шигтгэн дэвсэн байсныг өөрчлөн явган замын хавтанг бетон зуурмагаар бэхжүүлэн зориулалтын хашлага хийн тогтоох.

3. Автомашины зогсоолын хязгаарлах бүсийг modoор шийдсэн байсныг төмөр трубагаар /хөндлийг 76 диаметртэй, хөлийг 100 диаметртэй хар төмөр труба/ сольж нэмж нийт 18 метр болгон цагаан, цэнхэр будгаар алаглуулан будах.

4. Амрах зуны суудрэвчний сандал, ширээ, дээврийг янзлах /хөл хийх болон будах, ханзарсан хэсгийг нөхөх/


5. Хогийн савыг 1.5м3-с багагүйгээр шинээр төмрөөр хийж будах.
Нугастай тагтай байх

6. Тэмдэг, тэмдэглэгээ: Рашааны эрдэс бодис болон тус тус чанарын талаарх мэдээллийг агуулсан самбарыг рашаан авдаг хэсгийн хажууд байрлуулах.
/1.0x1.5 м/

7. Рашааны 5 ундаргыг тэмдэглэсэн жижиг шонт самбар босгож байрлуулах.

2. Гүйцэтгэл хийх хугацаа: 2019 онд

3. Онцгой нөхцөл: Үгүй

Боловсруулсан: Баян-Үул сумын
Засаг даргын орлогч  Ш.Төмөр-Ивээлт/

